

SOME CHALLENGING PROBLEMS OF CIVIL DECISION EXECUTION
AND WAYS TO SOLVE IT



Э.Батбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

Товч агуулга: Энэхүү өгүүллээрээ хорихоос өөр төрлийн ялын онцлог, төсөөтэй болон ялгаатай ойлголт, манай эрдэмтэн судлаачдын бичсэн мөн олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан талаар харьцуулан судалж, тодорхойлохыг зорилоо.

Abstract:. Abstract: This scholarly article seeks to undertake a comparative analysis of the characteristics of non-custodial sentences. It examines their similarities and differences, as well as the regulatory frameworks governing them within international treaties and national legislation, as articulated by our academic experts.

Түлхүүр үгс: Ял, хорихоос өөр төрлийн ял, торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял

Key words: Punishment, alternative penalty, non-custodial sentence, community service sentence, compulsory labour, travel restriction sentence, fine, disqualification sentence

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын Эрүүгийн хуульд хорихоос өөр дөрвөн төрлийн ял байдаг. Үүнд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах гэсэн 4 ялын төрөл багтдаг⁶¹.

Төр, хууль цаазын үүсэл зүйн үүднээс судлан үзэхэд “МЭӨ III - МЭ IV зуун буюу Ромын эзэнт гүрний хөгжлийн оргил үед анхны бичмэл хууль, цааз батлагдаж, хорихоос өөр төрлийн ялын төрлүүд бий болж эхэлсэн бөгөөд тухайн үед төлбөр тооцох ял (pactio, штраф) голлох байр суурийг эзэлж байсан” баримт бий⁶².

Хорихоос өөр төрлийн буюу олон улсад “альтернатив ял” гэж нэрлэгддэг ял (alternative penalty) нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны

⁶¹ Д.Дамдинцэрэн. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлснээр хүний эрхийг дээдлэхийн зэрэгцээ эдийн засагт ч хэмнэлттэй. <https://www.ncs.cd.gov.mn/?p=25750>.

⁶² ННФ. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт /судалгааны тайлан/. УБ., 2022., 22 дахь тал.

дараа нийгмээс тусгаарлаж, тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг⁶³.

Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлогоо хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзах, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай болжээ⁶⁴.

2015 оны Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлалд “шүүх хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах өргөн боломжтой, хорих ялын дээд ба доод хэмжээг сунгаж, харьцангуй уян хатан байдлаар тусгана. Ингэснээр “гэмт хэргийн ангилал, шүүхээс оногдуулах ял хоорондоо уялдаагүй, хатуу хязгаарын хүрээнд, гэм бурууд тохирохгүй ял оногдуулдаг” гэсэн шүүмжлэл багасаж, шударгаар хэргийг шийдвэрлэхэд дөхөм болно” гэж авч үзсэн байна⁶⁵.

Гэмт хэргийн гаралт буурах, эрүүгийн нөхцөл байдал хэвийн түвшинд байх, дахин давтан гэмт хэрэг үйлдэгдэх байдал багасах, нийгэм хэр хүнийрхэгдэж буюу хүмүүнлэг болж буй зэрэг нь ялын үр нөлөөг хэмжих нэг шалгуур юм. Гэмт явдалтай тэмцэхэд ял бол гол хэрэгсэл биш байж болох ч хүн төрөлхтний түүхэн янз бүрийн үе шатанд гэмтнийг гэсгээн цээрлүүлэхэд төрийн нэрийн өмнөөс хэрэглэдэг ялаас өөр үр дүнтэй хэрэгслийг хараахан бодож олоогүй явж ирлээ.

Хүний эрхийг хязгаарладаг, хүнд цээрлэл үзүүлдэг, нэр төрийг сэвтүүлдэг ял нь үйлдсэн нүгэлт хар муу үйлдлийн төлөө хэрэглэж байгаа зэм боловч гэмт хэргийн нийгмийн хор аюул, тэр тусмаа өсөлтийг хязгаарлаж, зогсоож чадахгүй болох нь нийгмийн амьдралын бодит практикаар нэгэнт батлагдсан.

Суурь зарчмын хувьд Монгол Улс Эрүүгийн хуулийн ялын бодлогын шинэ философи руу шилжлээ гэж харж байна. Шинэ Эрүүгийн хуулийн гол үзэл баримтлал нь ялын бодлогын шинэчлэл бөгөөд заавал хорих ял оногдуулахгүй байх тухай асуудал юм. Хүнийг шоронд хийчхээд түүнтэй ажиллана гэдэг бол оройтсон асуудал төдийгүй мэргэшсэн гэмт хэрэгтэн бэлтгэх, гэмт хэргийн карьер өсөхөд шууд нөлөөлдөг. Дэлхийн бусад улсын жишгийг харвал хорих ял өгөхөөсөө илүүтэй гэмт хэрэг үйлдсэн хүнтэй хохирол, хор уршиг, гэм буруугийн асуудлыг судлан үзсэний үндсэн дээр ял өгөхгүйгээр 20-30 төрлийн албадлага, нөлөөлөх арга хэмжээ авчхаад, болохгүй бол хорих ялын асуудал ярьдаг. Ийм учраас гэмт хэрэгтэнд засрах, гэм хороо арилгах боломж гардаг. Манайх болохоор

⁶³ Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017., 411 дэх тал.

⁶⁴ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018., 29 дэх тал.

⁶⁵ ХЗЯам. Эрүүгийн хуулийн төсөл. УБ., 2015., 11 дэх тал.

нэгийг нь шоронд хийж, нөгөөх нь хохирлоо барагдуулж чадахгүй хохирсноороо үлддэг систем явж ирсэн юм⁶⁶.

Ингэхдээ ял нь хэрэгтэнд хатуу цээрлэл амсуулахын зэрэгцээ түүнийг засах, хүмүүжүүлэх шаардлагатай болохыг ойлгосон учир ял эдлүүлдэг янз бүрийн тогтолцоо, арга хэрэгслийг тухайлбал: олноор нь хорих, хүнд хөдөлмөр хийлгэх, ганцаарлан хорих, хөл гарт нь гав гинж зүүх, хоол унд өгөхгүйгээр удаан байлгах гэх зэрэг хүнлэг бус аргуудыг бодож хэрэглэж байсан боловч хүсэн хүлээсэн үр дүнд хүрээгүйгээр үл барам хоригдогсдын зүгээс жигшил, зэвүүцэл, үзэн ядалтыг улам дэвэргэж өгсөн байдаг. Тийм ч учраас хоригдлууд шоронгийн харгис дэглэм, дарамтыг эсэргүүцэж үймээн самуун ихээр гаргах болсон тул ... зарим улс оронд хорих ял эдлүүлэх өвөрмөц арга замыг сонгож, жишээ нь: Латин Америк болон АНУ-ын муж улсуудад ажлын 5 өдөр ар гэрт нь байлгаж, хагас, бүтэн сайн өдрүүдэд хорих ялыг эдлүүлэх болжээ⁶⁷.

Хүн төрөлхтний гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн түүх их сонин. Эхний 1000-аад жилд дэлхийн олон орон гэмт хэрэг үйлдсэн хүнийг маш олон төрлөөр цаазлан алж хороож байсан. Ингээд асуудал шийдэгдээгүй, гэмт хэрэг улам харгис болоод байсан. Үүний дараа олон янзаар хорьдог л болсон. Энэ нь тодорхой хэмжээнд сайн талууд үзүүлсэн ч бас сөрөг үр дагавартай байсан. Шоронгоос гарсан гэмт хэрэгтэн маш олон асуудал дагуулсан. Иймд хорихоос гадна нийтэд тустай ажил хийлгэх, торгох, хянан харгалзах арга хэмжээний хүрээнд тэр хүмүүст нөлөөлдөг, гэмт хэргийн улмаас учирсан хор хохирлыг нь арилгуулдаг байя, тэр хүнийг өөрийг нь өөрчилдөг байя гэсэн ийм л хөшүүрэг, механизмыг ярьж байна⁶⁸.

Ер нь үндэслэлтэй болон үндэслэл муутай ялын санкцийг чангаруулах бараг бүх тохиолдолд үр дүн багатай гэдэг нь батлагдсан.⁶⁹ Дан ганц хорих ялтай байсан санкц багасаж, сонгох буюу хорихоос өөр төрлийн ялтай санкц эрс нэмэгдсэн нь гэмт хэрэгтэнд ял оногдуулахдаа цээрлүүлэлтийн арга хэрэгслүүдийг хэмнэж ашиглах зарчимтай холбоотой юм. Хэрэв хатуу ялыг их хэмжээгээр хавтгайруулан ногдуулбал, ялангуяа хорихоос өөр төрлийн ялын нэр хүнд буурч, гэмт хэрэгтэй тэмцэх үр нөлөөтэй хэрэглүүр болж чаддаггүй байна⁷⁰.

Тиймд энэ үндсэн дээр орчин цагт ял нь хорих болон хорихоос өөр төрлийн ял гэж зааглагдаж буй хандлага түгээмэл болсон учир хорихоос өөр төрлийн буюу

⁶⁶ Үз. <https://itom.mn/article/3097>. Г.Оюунболд. Хохирогч хохирч үлддэггүй, хорих ялыг заавал биечлэн эдлүүлдэггүй болно. Г.Улсболд. Нийтэлсэн огноо. 2016.01.07.

⁶⁷ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Ялын тухай сургаал. Боть-II., УБ., 2014., 17, 20 дахь тал.

⁶⁸ Эх сурвалж. semuun.niitlech.mn/content/6108.shtml. Г.Эрдэнэбат: Тэгвэл бүгдээрээ зодолдоод л амьдаръя.

⁶⁹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Ялын тухай сургаал. Боть-II., УБ., 2014., 20 дахь тал.

⁷⁰ С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., 1999., 275 дахь тал.

нийгмээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгаарлахгүй шинжтэй ялуудын ялын тогтолцоонд эзлэх байр суурь, онцлог шинжийг тодорхойлох нь чухал болов.

Нэр томьёоны хувьд гадаад улс орнуудад хорихоос өөр төрлийн ялд “нийгэм - олон нийтэд тулгуурласан ял (community sentence, community based sentence); Сонгох ял (alternative sentence); Хорихоос өөр төрлийн ял (non-custodial sentence) зэргээр оноолт өгсөн боловч, агуулгын хувьд ерөнхийдөө ижил байна.

Хорихоос өөр төрлийн ялын үүсэл зүйг XVIII – XIX зууны соён гэгээрүүлэх буюу хүмүүнлэгийн философийн хөгжлийн үетэй холбож, энэ үеэс бие махбодын хүнд шийтгэл, цаазаар авах, урт удаан хугацаагаар хорих явдлын оронд сонгох боломж бүхий өөр ялуудыг хэрэглэх болсон гэж үзэх нь түгээмэл.

Судалгаанаас үзэхэд хорих ял нь хорихоос өөр төрлийн ялтай харьцуулахад дараах онцлогтой. Үүнд:⁷¹

- хорих ялын хувьд “хүмүүжүүлэх” ба “цээрлүүлэх” гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Цээрлүүлэх хэлбэр нь зөвхөн хуулиар тогтоосон нөхцөл, журам, эрхийн хязгаарлалтын хүрээнд, тодорхой хугацаагаар байлгах мөн чанарыг илэрхийлнэ. Энэ утгаараа хорих ялд хүмүүжлийн гэхээсээ илүүтэй залхаан цээрлүүлэх шинж давамгайлна. Хорих газарт хэрэгжүүлж байгаа хөдөлмөрийн үйл ажиллагаа нь чөлөөт сонголтын бус албадлагын хэлбэрээр явагдана. Хоригдлыг нийгмээс тусгаарлан хүмүүжүүлнэ гэдэг ялангуяа өнөөгийн нөхцөлд боломжгүй байгаа нь практикаас харагдаж байна;

- хорих ялд хүнлэг бус шинж чанар давамгайлдаг, учир нь хорих ял эдлүүлэх дэглэм нь гол төлөв цээрлүүлэх аргад тулгуурлах тул энэ хугацаанд хоригдлын зүгээс аливаа чөлөөт үйлдэл хийх, авьяас чадвараа хөгжүүлэх боломж хязгаарлагддаг;

- хорих ял нь бусад ял шийтгэлээс илүү хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож байдаг. Хорих ял нь хоригдлын эрх зүйн байдалд дараах хэлбэрээр нөлөөлнө.

а/ хоригдлын зарим эрх, эрх чөлөө бүрэн хязгаарлагдана (чөлөөтэй зорчих, сонгох сонгогдох эрх);

б/ хоригдлын зарим эрх, эрх чөлөөнд тодорхой хугацаанд хязгаарлалт тогтооно (хувийн халдашгүй байдал, захидал харилцаа);

в/ хоригдолд түүний хувийн зан байдалд нийцүүлэн зарим төрлийн эрх, үүргийг нөхцөлтэйгөөр тогтооно (хувийн ариун цэврийг чанд сахих, хорих байрны дотоод журмыг дагаж мөрдөх);

⁷¹ ННФ. Зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилт /судалгааны тайлан/. УБ., 2022., 14-16 дахь тал.

г/ хорих газрын алслагдсан байдал зэрэг ял шийтгэлийн агуулгад хамаарахгүй хүчин зүйлс хоригдлын эрх зүйн байдалд нөлөөлнө;

д/ хорих газрын дотоод дэглэмээс гадна хоригдлын дунд “бичигдээгүй хууль” байдлаар тогтсон эрүүгийн шинжтэй хүчин зүйлс тодорхой нөлөө үзүүлнэ (бусад хоригдлын зүгээс үзүүлэх дарамт шахалт, тогтсон дэглэм). Өөрөөр хэлбэл, хорих ял эдлэх нөхцөл нь хүнийг засаж хүмүүжүүлэхээс илүүтэй “гэмт хэргийн мэргэшлийн дамжаа” болох магадлалтай.

Эдгээр хүчин зүйлс нь хоригдлын хүмүүжил, зан үйл, сэтгэл санаа, бие бялдар, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ нийгэмшүүлэхэд хүндрэл үүсгэдэг. Энэ нь нийгмийн зүгээс хорих ялыг гол төлөв эергээр хүлээн авдаггүй тул хорих ял эдэлсэн байдал нь хүний амьдралд насан туршийн “хар толбо” болон үлддэг.

Дээрх бүхий л сөрөг үр дагаврыг даван туулах үр дүнтэй арга замд нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл зүй ёсоор тооцогдож байна. Учир нь хорих ялыг бодвол нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн хүмүүжлийн арга барил давамгайлна.

Хорихоос өөр төрлийн ял нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, түүнчлэн үйлдсэн гэмт үйлдлийг засаж залруулах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлэх явдлыг эрс шүүмжилсэн, нийгэм-олон нийтэд ил тод, нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг, тусламжид тулгуурласан хэлбэртэй байхын зэрэгцээ эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй, ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ял шийтгэлийн хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь өнөөг хүртэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг залхаан цээрлүүлэх, тарчлаан зовоох хэлбэрийн арга барил шүүхийн болон хууль сахиулах практикт амь бөхтэй оршсоор байна.

Иймд олон нийтийн зүгээс эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй, ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлж эхэлсэн. Эдгээр арга замын нэг нь “нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” буюу “хорихоос өөр төрлийн ял” юм.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлд ялтны зарим эрхийг тодорхой болзол, нөхцөлтэйгөөр хязгаарлах замаар оноож буй ял шийтгэлийг ойлгоно. Уг ялыг тухайн этгээдийн хувийн зан байдал, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн төрөл, нийгэмд учруулсан сөрөг үр дагавар, хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж оногдуулна.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлийн давуу тал нь “хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан; ялтныг засаж хүмүүжүүлэх болон нийгэмшүүлэх боломжтой; Эдийн засгийн хувьд хэмнэлттэй” зэрэгт оршино.

Олон улсын туршлагаас харахад ялын сонгох хувилбарын хүрээг тэлж өргөжүүлэхийн тулд юуны өмнө тухайн орны эрүүгийн болон ял, шийтгэл гүйцэтгэх тухай хуульд⁷² нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ялыг⁷³ түлхүү тусгасан.

Үүний тулд “ялын бодлогыг өөрчлөх; салбар хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах; эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрчлөн шинэчлэх; шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийн үзэл баримтлалыг илүү хүнлэг, энэрэнгүй болгох; сонгох хувилбараар оноох ял шийтгэлийн хэлбэрийг өргөжүүлэх замаар хорих ялыг оноох, албадлагын бусад арга хэмжээ хэрэглэх үндэслэл, шаардлагыг улам уян хатан болгоход гол анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

Ял шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд “ялтанд үзүүлэх нөлөөллийн арга хэмжээний агуулга, арга барилыг боловсронгуй болгох; ял шийтгэл хэрэгжүүлж буй орчин нөхцөлийг сайжруулах; ялтныг нийгэмшүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Эдгээр шаардлагыг хорих ялаар хангах боломжгүй болох нь олон жилийн практикаас харагдаж байна.

Ялын бодлого бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд ялын оновчтой төрөл, хэлбэрийг хуульчлан тогтоож, сонгон хэрэглэх тухай үзэл баримтлал юм.

Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад хорих ял эдлээд суллагдсан этгээд давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй⁷⁴ байна. Энэ нь хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хүлээсэн чиг үүрэг тодорхой бус, хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоо байхгүй зэрэгтэй холбоотой.

Өөрөөр хэлбэл, ялын тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх, гадаадын зарим орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын туршлагаас суралцан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэх нь зүйтэй.

⁷² МУ-ын хувьд уг хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай гэж нэрлэдэг.

⁷³ МУ-ын хувьд уг ялыг “хорихоос өөр төрлийн ял” гэж нэрлэсэн байна.

⁷⁴ 2024 оны жилийн эцсийн дүнгээр нийт ял эдэлж буй хоригдогсдын 52 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн байна.

Тухайлбал: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийг 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал зохицуулалт болсон билээ.

Эл Токиогийн дүрэм нь⁷⁵ хорих ялын хэрэглээг багасгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэх зорилгыг агуулж, нийгмийн болон хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд хохирогчтой зөвлөлдөж байхыг зөвлөжээ.

Мөн энэ дүрэмд хорихоос өөр төрлийн арга хэмжээнд хэрэглэх үндсэн зарчмыг тусгасан⁷⁶ бөгөөд дүрмийн гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмийн хэвийн амьдралд эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүүтэй дахин гэмт хэрэг үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох явдлаас сэргийлэх, төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлэх юм.

Үүнээс гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ үр дүнтэй байгаа тохиолдолд хугацаанаас нь өмнө уг арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох, үр дүнд хүрээгүй тохиолдолд шууд хорих ял хэрэглэхээс зайлсхийн хорихоос өөр төрлийн арга хэмжээгээр солих зэрэг зохицуулалтыг санал болгосон байна.

Түүнчлэн хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий алба хаагч нь амьдралын туршлагатай, мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирох хүн байвал зохино хэмээн тусгайлан заажээ.

Тус дүрмийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох бололцоотой нөхцөлд шүүх байгууллага дараах байдлаар шийдвэрлэж болохоор зохицуулсан. Үүнд:

- a/ сануулах, зэмлэх, буруушаах зэрэг аман арга хэмжээ;
- b/ хариуцлагаас тэнсэн чөлөөлөх;
- c/ иргэний зарим эрхийг нь хасах;
- d/ нэг удаагийн болон өдрийн торгууль зэрэг мөнгөн шийтгэл, эдийн засгийн арга хэмжээ;
- e/ хөрөнгө хураах, эд хөрөнгө өмчлөх эрхийг нь хасах тогтоол;
- f/ хохирогчид эд хөрөнгийг нь буцааж өгөх, хохирол төлөх тогтоол;

⁷⁵ Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 159 дэх тал.

⁷⁶ Үз. НҮБ-ын Ерөнхий Ассамблей. Токиогийн дүрэм. “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм”, 1990.

g/ тэнсэх, шийтгэлийг хойшлуулах;

h/ хорихоос тэнсэн суллах болон шүүхийн хяналт;

i/ нийгмийн тустай хөдөлмөр хийлгэх тухай тогтоол;

j/ тодорхой газар нутагт заавал ирж бүртгүүлж байх болзол тогтоох;

k/ гэрийн хорио;

l/ хорихтой холбоогүй бусад арга хэмжээ;

m/ дээр дурдсан арга хэмжээнүүдийг хослуулан хэрэглэх. Эдгээр нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд, ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэглэнэ. Мөн хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явцад уг этгээд эрх нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхтэй байхаар заасан.

Олонх гэмт хэрэг хорих ялтай, шүүх хорих ангийн төлөвлөгөө биелүүлэгч болж хувирч хавтгайруулж ялладаг зэргээс нийгэм бүхэлдээ шоронжих, энэ нь үндэсний аюулгүй байдлын хэмжээнд тулж очтолоо хүндэрсэн гэсэн шүүмжлэл байдаг нь бодит үнэнээс нэг их зөрөхгүй юм.

Энэ талаар мартахын аргагүй **түүхэн сургамж** бийг өгүүлбэл: 1984 онд МАХН-ын Төв хороо 316-р тогтоол гаргаж түүнд хорих ял тэнсэх, хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах журмыг аль болохоор хэрэглэхгүй байх чиглэлийг Дээд шүүхэд өгч, энэ үндсэн дээр тэр үеийн дээд шүүхийн бүгд хурал өмнө нь дурдсан эрүүгийн эрх зүйн институтийг үлэмж явцуу хүрээнд хэрэглэх тухай тогтоол гаргасан юм. Үүний дараа тэнсэх явдал үлэмж багасаж шоронгууд ачааллаа даахгүйд хүрчээ. Үүнтэй зэрэгцэн рецидив гэмт хэрэгтний тоо үлэмж өссөн нь статистикаас харагддаг. Энэ байдлаас гарахын тулд тэр үеийн АИХ-ын тэргүүлэгчид Өршөөл үзүүлэх зарлиг гаргаж олон хүнийг ялаас чөлөөлсний дараа сая хэвийн байдалд орж байсан байна⁷⁷.

Нэг талаараа ял оногдуулах үйл явцад гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрд зохих ялыг шударгаар оногдуулахын зэрэгцээ гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрхийг хамгаалах, нэр төрийг сэргээх явдлыг хангах зарчмыг чухалчлах учиртай. Нөгөө талаар ял оногдуулсны үр дүнд гэмт этгээдэд зохих цээрлэл мэдрүүлэх, дахин давтан гэмт хэрэг үйлдэхгүй байх, гэмт хэргийн өсөлт /гаралт/ буурах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрүүгийн хуулийн зорилт, төрийн эрүүгийн бодлого хангагдах ёстой.

Иймд ямар нэг гэмт хэрэгт сэрдэгдэж шалгагдаад суллагдсан буюу ял шийтгэх, гэм буруутайд тооцох үндэслэлгүй болох нь тогтоогдсон хүн эцэстээ нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлээрээ хохирох ёсгүй атал бидний өнөө цагт ийм мэт гэм буруугүй хүмүүс яагаад өөр хувь заяа, жам бус тавилантай учирч буй гэж, энэ

⁷⁷ С.Нарангэрэл. МУ-ын Эрүүгийн хуулийн төслийн талаарх санал. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2006., №2/16/., 31 дэх тал.

нь эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоо бүхэлдээ буруу хууль, харалган бодлого, хатуу харгислал, хүчирхийллийн үзэл санаанд нэвт идэгдсэн, өнгө мөнгө, үзэмж давамгайлсан, сэтгэхүй илт хоцрогдсон, бүдүүлэг хэв шинж, зан авираас ангижраагүй, хуурмаг нотлох баримтад хэт их итгэж дотоод итгэлээ алдсан, шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцдаггүй, гэм буруугүй гэж тооцогдсон этгээдийн эрх нөхөн сэргэх механизм зогсонги зэрэгтэй холбоотой бөлгөө.

Практикт хуульгүй мэт аашилж, зүйлчлэл буруу хийж байгаа болохоор ийм мэт зүй бус байдал арилна гэдэг бас л хол хөндий юм, гэхдээ энэ бол ажилдаа хайнга хандахгүй байх, жаахан л сэтгэл зүрх гаргах, басхүү хувийн сонирхол үл гаргах, мэдлэг чадвараа дээшлүүлбэл шууд л болчих явдал тул тийм ч их алс ирээдүйн, биелшгүй мөрөөдөл биш билээ.

Удаан хугацаагаар нийгмээс сайн муу нэр зүүж, нийгэмд аюултай гэж утгагүй зүйлээр үндэслэлгүй цоллож тусгаарлалтаар эргээд нийгэмшүүлэх гэж үйл тамаа үзэж, махаа барж буй нь өдгөө үнэн. Одоогийн дүр төрх ийм л байна. Цаашид яах ёстой вэ гэдэг л байгаа мэт боловч байгаа эрх зүйн орчинд ажиллах ур ухаан, мэдлэг дутаж байгаа нь ихэд харуусмаар байдал болж буй юм хэмээн санагдана.

Эх газрын эрх зүйн системийн бүх оронд ял оногдуулах нийтлэг нөхцөл, үндэслэл, журмыг эрүүгийн хуулиар зохицуулж тогтоосон байдаг ба 1-рт ялын хууль ёсны байх /rule by law/, 2-рт ялыг хувь хүнд оногдуулах /нэг бүрчлэн - individulization/ гэсэн 2 зарчмыг гол баримтлалаа болгодог.

Ийм зарчим Герман, Итали, Франц, Хятад, Унгар, Солонгост буй бол харин Бельги, Нидерланд, Норвеги, Парагвай, Япон болон Англи-Америкийн системийн орнуудад ийм зарчмыг бус ялын гарцаагүй, үр нөлөөтэй, шударга байдлыг зөв бодитой хангахад нийтлэг шаардлага нь чиглэгддэг.

Постсоциалист орнууд болон Орос, Монгол, Хятад зэрэгт **нийгэмд аюултай байдлыг** ял оноход харгалзах гол хүчин зүйлийн нэг гэж үздэгээс үүдэн объектив шалгуурыг чухалчилдаг материалист хандлага зонхилдог бол эх газрын системийн барууны чиглэлийн болон Англи-Америкийн системийн орнуудад гэмт хэргийн хууль зүйн үр дагавар, хууль зөрчигдсөн болон хувь хүн, гэр бүл, улс оронд хор нөлөөтэй гэж үздэгээс үүдэн субъектив шалгуурыг чухалчилдаг натуралист болон либералист хандлага илүү тод илэрч байдгийг харж болно⁷⁸:

Олон Улсын ял оногдуулах зарчимд тодорхой санкцийг хуульчлан, оногдуулах явдлаас аль болох зайлсхийн, алтернатив нөхцөлийг тодорхой боломжит шийдлээр зохицуулах, хүнд биш хэргийн хувьд хянан харгалзах, торгох ялыг өргөн хэрэглэх, баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох, торгуулийг сүүлийн 6 сар хүртэлх сарын дундаж орлогоор тооцох, мөнгөн дүнгээр

⁷⁸ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011., 167 дахь тал.

илэрхийлэх, хорихоос өөр төрлийн ялыг өргөжүүлэн, ял солих процедурыг оновчтой хэрэглэх практик түгээмэл хэрэглэгдэж байна⁷⁹.

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуульд нийт 1088 үйлдлийг гэмт хэрэгт тооцож “хорих, торгох, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах” ялын төрлийг үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулах тухай заажээ⁸⁰.

Харин эрүүгийн ялын бодлогын хүрээнд дэлхий дахинд дараах өөрчлөлт хийгдэж байна. Үүнд:

- цаазаар авах ялыг халах (99 улсад бүрэн халсан, зөвхөн 58 улсад хэрэглэдэг);

- бие махбодын шийтгэлээс татгалзах (33 улсад л хэрэглэдэг);

- цөллөгийн хөдөлмөрийг халах (Европ, Ази тивийн олон улс, АНУ-ын хууль тогтоомжоос хассан);

- нийт хөрөнгө хураах ялаас татгалзах (Франц, Монгол, Зүүн Европын улсууд);

- хорихоос өөр төрлийн ял хэрэглэх (торгууль, албадан ажил, тэнсэн, нийтэд тустай ажил, гэрийн хорио);

- эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг нэмэх (хохирогчтой эвлэрсэн, аргагүй хамгаалалтын хэмжээ хязгаарыг өргөтгөсөн, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар гэсэн ойлголт бий болсон);

- насанд хүрээгүй гэмт хэрэгтний эрүүгийн эрх зүйн шийтгэлийг өргөтгөх;

- олон үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо больж, захиргааны зөрчлийн хэмжээнд авч үзэх (жижиг хулгай, танхай, үр хөндөх г.м).

ДҮГНЭЛТ

Улс орнууд хүмүүнлэгийн чиглэлийн хүрээнд өөрчлөлт хийгээд эхэлжээ. Баруун Европын дийлэнх улс орон цаазаар авах ялыг халсан ба албадан ажил хийлгэх, эд хөрөнгийг бүхэлд нь хураах ялыг хязгаарлаж, нийгмийн үйлчилгээ, хөтөлбөрт хамруулах, нөхөн төлбөр оноох ялыг орлуулан сольж ялын бодлогодоо өөрчлөлт оруулсаар байна⁸¹.

⁷⁹ Үз. Б.Алтангэрэл. “Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ” судалгааны ажлын тайлан. УБ., 2018.

⁸⁰ Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “МУ-ын Эрүүгийн хууль дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. “Сүлд-Инфо” сэтгүүл. УБ., 2021., 53 дахь тал.

Ял нь гагцхүү Эрүүгийн хуульд тусгалаа олсон байх, ингэхдээ маш тодорхой бөгөөд үндэслэлтэй томъёологдсон, хуулиас гадуур хэнийг ч яллахгүй байх, хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй байх, шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх, эзнээ олсон, оновчтой, үр нөлөөтэй, тогтвортой, улс орны онцлог, нийтийн эрх, ашиг сонирхолд нийцсэн, ганц нэг нэмэлт, өөрчлөлт төдийгөөр хандах бус төрийн зөв бодлого, шийдвэрт хөтөлбөр болж үзэл баримтлалын хэмжээнд томъёологдож гарах нь хууль ёсны зарчим бүрнээ хэрэгжих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдлын хувьд манай улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлд нэгэн чухал алхам болно гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖ

1. С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/ УБ., 1999.
2. С.Нарангэрэл. МУ-ын Эрүүгийн хуулийн төслийн талаарх санал. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2006., №2/16/.
3. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Ялын тухай сургаал. Боть- II., УБ., 2014.
4. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011
5. Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018.
6. Б.Алтангэрэл. “Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ” судалгааны ажлын тайлан. УБ., 2018.
7. Г.Оюунболд. Хохирогч хохирч үлддэггүй, хорих ялыг заавал биечлэн эдлүүлдэггүй болно. Г.Улсболд. <https://itom.mn/article/3097>. Нийтэлсэн огноо. 2016.01.07.
8. Г.Эрдэнэбат: Тэгвэл бүгдээрээ зодолдоод л амьдаръя. semuun.niitlech.mn/content/6108.shtml.
9. Д.Дамдинцэрэн. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлснээр хүний эрхийг дээдлэхийн зэрэгцээ эдийн засагт ч хэмнэлттэй. <https://www.ncs.cd.gov.mn/?p=25750>.
10. Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017.
11. Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “МУ-ын Эрүүгийн хууль дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. “Сүлд-Инфо” сэтгүүл. УБ., 2021.
11. НҮБ-ын Ерөнхий Ассамблей. Токиогийн дүрэм. “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм”, 1990.
12. Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012.
13. ХЗЯам. Эрүүгийн хуулийн төсөл. УБ., 2015., 11 дэх тал.
14. ННФ. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт /судалгааны тайлан/. УБ., 2022.